



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар A/12

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Биеийн тамир спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулж буй "Даатгуулагчийн нэрэмжит волейбол"-ын тэмцээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын баг хамт олныг оролцоход зориулж 115000 /нэг зуун арван таван мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын биеийн тамир, уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР